



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 25


Улаанбаатар хот

“Цагаан толгой трейд” ХХК-д хувьцаа эзэмшигчийн
бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цагаан толгой трейд” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд хавсралтад заасны дагуу өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Цагаан толгой трейд” ХХК /Т.Уянга/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны 2022
оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
25 дугаар тогтоолын хавсралт



“Цагаан толгой трейд” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орох өөрчлөлт

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс /регистрийн дугаар/	Нэрлэсэн үнэ	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь	Хувьцааны тоо	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь
1	Т.Уянга /ХО 76061266/	1,000.00	15,100	15,100,000.00	100%	-15,100	-15,100,000.00	-	-	-
2	Ч.Хишигсүрэн /ЦЕ86041463/	-	-	-	-	+7550	+7,550,000.00	7550	+7,550,000.00	50%
3	Б.Нарандулам /ЛЮ85062763/	-	-	-	-	+7550	+7,550,000.00	7550	+7,550,000.00	50%
	Нийт	1,000.00	15,100	15,100,000.00	100%			15,100	15,100,000.00	100%